

Манмин Мэдээ

№ 42 2014 оны 1 сарын 5

“Шинэхэн бөгөөд үр нөлөөтэй, үзэх тусам сэтгэл хангалуун, GCN TV-ийн шинэ хөтөлбөрүүд олны анхаарлыг татаж байна”



GCN TV 2005 оны 10 сард нээгдсэнээс хойш улам бүр өргөжин тэлж дэлхийн хэмжээнд нөлөө бүхий Христчин нэвтрүүлэгийн төв болж чадсан билээ. Энэ жил GCN TV эцсийн үеийн авралын зорилгыг улам гүйцэлдүүлэхийн тулд өөр нэгэн гайхамшигтай ер бусын өөрчлөлтийг хийлээ. 2013 оны 10 сарын 14нд GCN TV-ийн хамгийн анхны шинэ хөтөлбөрүүд болох Бурханы сэтгэлд нийцсэн жинхэнэ хүүхдүүд болох арга замыг үзүүлсэн шинэ логотой, телевизийн нэвтрүүлгийн шинэ хөтөлбөртэй боллоо. (Зурагнууд: шинэ хөтөлбөрүүдийн зурагт хуудаснууд)

GCN TV нь Бурханы хүч чадал, ариун зар, сайн мэдээг тараах зорилготой бөгөөд Манмин Төв Сүмийн 31 жилийн ойн баяраар цоо шинэ алхам хийж, анх байгуулагдсан цагаасаа эхлээд техник технологи, мэдлэг, санхүүгийн байдал, ажиллах хүчээр дутмаг байсан ч зөвхөн итгэлээрээ үйлчлэлд өөрсдийгөө бүрэн зориулсаар ирсэн GCN TV нь одооноос эхлэн Бурхан Аав, Хүү, Ариун Сүнс гэсэн Ариун гурвал Бурханыг билэгдсэн ураг гэрлийн гурван цацраг, бүх дэлхийд Ариун сайн мэдээгээр дүүргэх алсын хараа бүхий логотойгоор үзэгчиддээ уулзаж байгаа юм.

Үүнтэй хамт 2013 оны 10 сарын 14-өөс хойш олон төрлийн шинэ нэвтрүүлэгийг явуулж маш олон үзэгчдээс магтаал сайшаал илэрхийлсэн санал хүсэлтийг хүлээн авсаар байна. Сүмийн үйлчлэлд өөрсдийгөө зориулж буй пастор, ахлагч нар үзэгчдийн сонирхолыг татах Бурханаас өгсөн 19 шинэ нэвтрүүлэгийг үзүүлж байна.

Үүнд “Бидний амьдрал доторх гэрэл” гэсэн И Жей Руг тэргүүн пасторын сургаалын нэвтрүүлэг, үзэгчдийн итгэлээр өсөхийн тулд бэлтгэгдсэн “И Сү жин пасторын ТВ сургаал” Бурханы хайр дотор энэ өдрийг ялан дийлэхэд зориулагдсан И Хи жин пасторын сургаал, зөвлөгөө “Эзэний бодол” нэвтрүүлэг, И Хи сон пасторын нүдэнд үл үзэгдэх сүнслэг ертөнцийн гайхамшигуудыг тайлбарлах “Сүнслэг Ертөнц”, (MIS) Манмин Олон улсын Библийн сургуулийн захирал Жон Гү ён пастор болон Шин Дун чу пасторын Христчин

хүмүүсийн ариун амьдралын төлөө болон чуулганы амьдралын тухай мөн Библийн ойлгоход хэцүү ишлэлүүдийг тайлбарласан “Амийн Ус” гэх мэт олон нэвтрүүлэгүүдийг тус тус үзүүлж байна.

Түүнчлэн Магтан дууны ахлагч Хан Роүз “Магтаалыг Өргөцгөө” гэсэн хөтөлбөр нь үзэгчдэд Манмины магтаал дууг дуулахад тусладаг бөгөөд амьсгаа, аялгуугаа яаж хувиарлах, тааруулах аргыг зааж өгдөг. “Анхилуун Үнэр” хөтөлбөрийн хөтөлгөч И Жин туслагч Манмины магтаалын хөгжмийн зэмсэгийг тоглодог арга, хөгжмийн анхан шатны мэдлэг ба Манмины магтаалын утга учрын тухай тайлбарладаг. Хан Дун шик туслагч ба Юү Шина туслагч нар бүх насны үзэгч сонсогч нарын анхаарлыг ихээхэн татаж хайрыг хүлээж байгаа “Жаргалтай, жаргалтай хөөрхөн бүжиг” гэх хүүхдүүдэд зориулсан бүжгийн хөтөлбөрийг бэлтгэж байна.

Дэлхийн Христчин Эмч нарын Холбоо (WCDN) нь “WCDN” хөтөлбөрөөрөө Бурханы эрх мэдэлт хүчийг анагаах ухааны хөдлөшгүй баримтаар нотлон харуулсан нэвтрүүлэг “Үзэсгэлэнт Магтаалын Үйлчлэл” хөтөлбөрөөр Бурханд магтаалын өргөл өргөх арга зам, зүрх сэтгэлийн хандлагыг заадаг, “Эргэцүүлэн бодохуй” хөтөлбөр нь Библийг уншаад хэрхэн тунгаан бодоход тусладаг, “Бид бол Нэг” хөтөлбөр нь Манмины бүх салбар сүмүүдийн талаарх мэдээлэлийг үзэгчдэд дамжуулдаг билээ.

Үүнээс гадна GCN TV нь Англи хэлний “English”, “Нэг Минутын Англи” хэл гэсэн

хөтөлбөрөөрөө англи хэлний үндсэн дүрэм, өдөр тутмын үг хэллэгийг жижиг сүмүүд болон бүх итгэгч нартаа зориулан зааж байгаа билээ. Орчин үеийн хүмүүс амьдралын буруу хэв маягаа засаж, жингээ барихад нь туслах зорилгоор иогийн дасгалуудыг заах нэвтрүүлэг зэрэг боловсролын хөтөлбөрөөр явуулж байна. “Цэцэгчин” гэсэн нэвтрүүлэгээр цэцэг цэцэглэх, чимэглэлийн тухай мэдлэгийг анхан шатнаас гүнзгий шат хүртэл нь зааж, “Өнөөдрийн цаг агаар” хөтөлбөрөөрөө жилийн 365 өдрийн цаг агаарыг бидэнд мэдээлж байгаа билээ.

Эдгээр хөтөлбөрүүдийг цацаж эхэлсэнээс хойш олон үзэгчид үзэх дуртай болж, нэг минут ч алдалгүй телевизийнхээ өмнө сууж нэвтрүүлгийн цагийг тэсэн ядан хүлээдэг болсон тухайгаа ярьж байгаа юм.

GCN TV 2005 оны 10 сарын 10нд Бурханы алдрыг тунхаглах, бүх үндэстний хүн нэг бүрт авралын зарыг тараах алсын хараа, зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ. Тиймээс Бурханы хайран дотор явагдсан гадаадын нэгдсэн их цуглаануудыг болон Манмин төв сүмийн үйлчлэлүүдийг дэлхий даяар цацаж байгаа билээ. Мөн дэлхийн 170 гаруй оронд амийн үг, эрх мэдэлт хүч, Христийн талаарх мэдлэг боловсролыг маш чанартай олон төрлийн хөтөлбөрүүдээр дамжуулан гаргаж байна. Манай хөтөлбөрүүдийг хэзээ ч, хаана ч, интернетээр (www.gcntv.org), мобайл гар утас, техник хэрэгсэлээр (m.gcntv.org) үзэх бүрэн боломжтой.

Хайр үнэнд баярладаг

“[Хайр] зөвт бус байдалд баярладаггүй, харин үнэнд баярладаг.” (1 Коринт 13:6)



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Хэрэв бид Бурханыг хайрладаг бол зөвт бусыг үйлддэггүй, үнэн зөв дотор л байдаг. Түүгээр ч үл барам үнэнд баярладаг. Хайр бол үнэн, зөвд баярладаг юм.

Иохан 14:6-г уншвал “Есүс ‘Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй’” гэсэн байдаг. Энэ ишлэлийг л харахад Есүс Христ бол жинхэнэ үнэн, Библийн 66 номонд бичигдсэн үг сургаал нь Бурханы үг юм.

Хэрэв Бурханыг хайрлаж, Түүнээс хайрыг хүлээж авбал бид туслаж чадахгүй ч Есүс Христтэй хамт баярлаж, үг сургаалиар Бурханы хаанчлал өргөжин тэлдэг байна. Тэгвэл үнэнд баярладаг гэдэг нь юу гэсэн үг юм бол?

1. Үнэнд баярлах

1) ‘Үг сургаалд’ баярлах

‘Сургаал’ гэдэг нь ‘сайн мэдээ’, Есүс Христээр дамжуулан бид аврагдаж Тэнгэрийн оронд орох болсон тухай сайн мэдээ юм. Өнөөг хүртэл бүх улс оронд олон хүн үнэнийг хайж байдаг. ‘Амьдралын зорилго чухам яг юу юм бэ? Амьдралын үнэ цэнэ юунд оршиж байна вэ?’ эдгээр асуултын хариултыг олохын тулд тэд үзэл бодол, философи судалж, эсвэл ямар нэгэн шашинаас хариултыг нь олохыг хичээдэг. Гэвч эдгээрээс хэн ч жинхэнэ үнэнийг олж авч чаддаггүй бөгөөд зөвхөн Есүс Христ бол жинхэнэ үнэн, Түүгээр дамжин Тэнгэрийн орон руу орно гэдгийг мэддэггүй юм.

Бид үг сургаал сонсож, Есүс Христийг хүлээн зөвшөөрч, авралыг хүлээн авч, мөнхийн амийг олж авсан юм. Бидний гэм нүгэл Эзэний цусаар уучлагдсан учраас тамд унах ёстой байсан бидний ирээдүй Тэнгэрийн оронд орох болж, үнэ цэнэтэй

амьдрах, амьдралын утга учрыг ойлгож мэддэг болсон билээ. Тиймээс бид энэ үг сургаалд баярлахгүй байхын аргагүй юм.

Ингэж үг сургаалд баярладаг хүмүүс бусад хүмүүст ч хичээнгүйлэн үг сургаал, сайн мэдээг тарааж, дамжуулж байдаг юм. Тэд Бурханы өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж, сайн мэдээг итгэлтэйгээр тараах болно. 1 Тимот 2:4-т “[Бурхан] Бүх хүнийг аврагдаасай, үнэний мэдлэг рүү ирээсэй гэж хүсдэг” гэсэн байдаг. Та Бурханы энэхүү хүслийг мэддэг бол олон хүмүүс сайн мэдээг сонсож, Эзэнийг хүлээн зөвшөөрч, аврал авч байгаа хүмүүсийн тоо улам бүр нэмэгдэхэд та баярлах болно.

Гэвч олон хүнд сайн мэдээ тарааж, арвин их үр жимстэй байгаа нэгнээ хараад зарим нь атаархдаг. Мөн зарим сүм чуулган Бурханд алдрыг өргөж, улам бүр өсөж байгаа сүм чуулганд ч атаархаж байдаг. Энэ нь үнэнд баярлахгүй байгаа хэрэг юм.

Хэрэв бидний зүрх сэтгэлд сүнслэг хайр байгаа л бол Бурханы хаанчлал гайхалтайгаар биелэхийг хараад баярлах болно. Биднээс илүү их үр жимстэй амьдралаар амьдарч, илүү итгэмжтэй итгэлтэй байгаа нэгнээ хараад баярлаж, Бурханы хайр ивээлийг авч өсөж хөгжиж яваа сүм чуулганыг хараад бид хамтдаа баясах болно. Энэ бол жинхэнэ сүнслэг хайраас гарсан үг сургаалд баярлах зүрх сэтгэл юм.

2) Үнэнд хамаатай бүх зүйлд баярлаж чадна гэсэн үг

Энэ нь сайхан сэтгэл, хайр, үнэн шударга гэх мэт үнэнд хамааралтай бүх зүйлийг харахдаа, сонсохдоо, үйлдэхдээ баярлахыг хэлж байгаа юм. Сайхан сэтгэлээр үйлдсэн өчүүхэн зүйлд ч баярладаг байна. Цаашлаад Бурханы үг үнэн, зөгийн балнаас ч илүү амттай учраас Библийг үргэлж уншиж, үг сургаал сонсохдоо баярлаж, Бурханы үгийг амьдралд хэрэгжүүлэхдээ ч баяртай байдаг.

Жишээ нь, ‘Үйлчил, ойлго, уучил’ гэсэн Бурханы үгэнд дуулгавартай байж дагахдаа баяртай байдаг. Энэ үгэнд дуулгавартай байдаг хүн үзэн ядах, атаархах, хорсох, шүүн дүгнэх, бусдад гомдож, ялархах дургүй харин ч бусад хүмүүс баян чинээлэг аз жаргалтай байхыг хараад чин сэтгэлээсээ баярладаг байна. Тэдэнд ямар нагэн атаархах сэтгэл байдаггүй. Тэдний хувьд ‘хэн

нэгэн хүн бүтэлгүйтээсэй, эсвэл бусдын зовлонд баярлах’ гэх мэтийн атгаг хорон санаа ердөө ч байхгүй, бодогдож, төсөөлөгддөг ч үгүй байна.

Тэд ямар нэгэн зөвт бус зүйлийг харахдаа зүрхнээсээ гашууддаг. Харин хувирашгүй зүрх сэтгэл, шударга байдал гэх мэт үнэнтэй, сайхан сэтгэлтэй холбоотой зүйлд зүрх сэтгэл нь хайраар дүүрч, сайхан үг, сайн үйлсэд баярладаг.

Бурхан хүүхдүүдээ харахдаа Зефаниа 3:17-д “Чиний Бурхан ЭЗЭН, аврагч дайчин, та нарын дунд байна. Тэр та нарын дээр баясал хөөртэйгээр баярлана. Тэр Өөрийн хайр дотроо чимээгүй байна. Тэр та нарын дээр баярын уухайгаар баясах болно” гэж айлдсанчлан баярлах болно.

Та үнэхээр чин сэтгэлээсээ үнэнд, зөвт байдалд баярлаж чаддаггүй юм байна гэж бодоод зориг мохож, сэтгэл тань тавгүйрхэж байна уу? Тэгвэл сэтгэлээр унаж, гутрах шаардлагагүй зүгээр л өөрийгөө нэг эргэж хараад шалгаад үзээрэй. Хэрэв та бүх чадлаараа хичээн зүтгэвэл Бурхан таны үнэнд баярлахыг хичээж байгаа зүтгэлийн тань хүртэл үнэлдэг болно.

3) Бурханы үгэнд итгэж, амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээхийг хэлнэ

Төрөхөөсөө л үнэн зөвт байдалд баярладаг хүнийг олоход маш хэцүү, ховор. Бид олон жил худал, хуурмаг, харанхуй дотор байж атгаг хорон зүйлийг бодож, зөвт бус байдалд баярлаж байдаг ирсэн билээ. Харин цаг хугацаа өнгөрөхөд зөвхөн залбирал, үг сургаалаар өөрчлөгдөж, гэмт зүрх сэтгэлээ хаясанаар үнэнд чин сэтгэлээсээ баярладаг болдог. Энэ хүртэл бид бүхэн сайн хичээн зүтгэх хэрэгтэй.

Бид үнэн үг сонсож, Бурханд итгэдэг. Мөн эцсийн шүүлтийн өдөр байгаа, Там, Тэнгэрийн Орон хоёулаа бодитоор оршин байдаг гэдэгт итгэдэг. Мөн бид Тэнгэрийн Оронд хүн нэг бүрт өөр өөр шагнал өгөгдөхийг ч бас мэддэг учраас зүрх сэтгэлээ бүр илүү ариусгахыг хичээж, бүх гэртээ итгэмжтэйгээр ажилладаг. Та магадгүй 100% зөвт байдалд баярлаж чаддаггүй ч өөрийнхөө итгэлийн хэмжээгээрээ дээд зэргээр хичээн зүтгэвэл энэ нь зөвт байдалд баярлаж байна гэсэн үг юм.

2. Үнэн ба зөвт байдлын төлөө өлсөж, цангах үед бидэнд асар их ивээл өрөөл өгөгддөг

Бурханы хүүхдүүд зөвт бус байдалд баярладаггүй харин үнэнд баярладаг учраас бидний бүх зүйлийг өөрчилж, шинэчлэх гайхамшигт хүч зөвхөн үнэнд л байдаг бөгөөд биднийг үзэсгэлэнтэй нэгэн болгодог юм.

Ариун үг сургаал сонсоны хирээр үнэний дагуу амьдарч, илүү төгс төгөлдөр жинхэнэ Бурханы хүүхдүүд болж өөрчлөгдөж чадна. Сүнслэг хайр, Тэнгэрийн Орны хүсэл мөрөөдөл, итгэл найдвараар дүүрэх үед бидний нүүр царай гэрэлтэх болно. Бид үнэн рүү өөрчлөгдөх тусам Бурханаас болон бусдаас хайрыг авч чаддаг учраас бидний амьдрал аз жаргал баяр баясалаар бялхам дүүрэн байх болно.

Бид үнэнд баярлаад зогсохгүй, үнэний төлөө өлсөж, цангах хэрэгтэй. Хэрэв бидний махан бие өлсөж цангавал идэж уухыг юу юунаас илүү их хүсэх болно. Яг үүнтэй адил үнэний төлөө өлсөж цангавал маш богинохон хугацаанд үнэний хүмүүс болж өөрчлөгдөж чадна. Тиймээс дандаа үнэнийг “ууж, идсэн” амьдралаар амьдрах шаардлагатай.

‘Үнэнийг ууж, иднэ’ гэдэг нь Бурханы үгийг зүрх сэтгэлдээ хадгалж, амьдралдаа хэрэгжүүлнэ гэсэн үг. Бурханы Үг бол үнэн зөв бөгөөд бидний амьдралд тохиолдсон хүнд хэцүү асуудал бүрийг шийдвэрлэх гол түлхүүр, ивээл ерөөлийн нууц, авралын зам, мөнхийн амьдрал юм.

Хайрт итгэгч нар минь, хэрэв та бүхэн үнэхээр Бурханыг хайрладаг бол үүнийг үйлсээр ил харуулах хэрэгтэй юм. Бид үнэний тухай харж, сонсох үед л чин сэтгэлээсээ баярлаж, аз жаргалтай байх болно. Тийм ч учраас хүмүүс “Та нэг л өөр, их аз жаргалтай харагдаж байна” гэж хэлдэг. Бид Бурханыг, Эзэнийг бодохдоо нулимс урсган талархаж, сайхан сэтгэлээр үйлдсэн жаахан зүйлд хүртэл нулимс урсган талархдаг болдог.

Хожим Тэнгэрийн Оронд нэг нэгнийхээ гэрт зочлохдоо гэрт нь байх үзэсгэлэнтэй гоёл чимэглэл нь хүмүүсийн төлөө гашуудан уйлах, баярлаж талархалын нулимс нь бүгд урсгасан гэрийн эзэний нь сайхан сэтгэлтэй холбоотой юм. Та бүхэн ч гэсэн үнэнд баярлаж, Бурхан Эзэндээ хайртай гэдгээ амьдралаараа батлан харуулсан та бүхнийг болохыг Их Эзэний нэрээр хүсэн гуйж байна.

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org

Өөрийн хил хязгаарыг ялан дийл!

‘Хил хязгаар’ гэдэг нь хувь хүний нийгэмд эзэлсэн байр суурь, эсвэл ямар нэгэн чадвар чадавхийг хэлдэг. Хүмүүст ихэвчлэн өөрийн хийж чадах чадвараас нь хэтэрсэн зүйл шаардвал “үүнийг хийж чадахгүй байх” гэсэн өөрийн хэмжээ хязгаарыг мэдэрдэг. Гэхдээ итгэл дотор ямар нэг хэмжээ, хязгаар байхгүй юм. Учир нь бүхнийг чадагч агуу Бурханд итгэж буй хүний хувьд боломжгүй зүйл гэж байхгүй. Тэгвэл яаж өөрийн хил хязгаараа давж чадах вэ?

1

Өөрийн хүрээ, хил хязгаараа өөрөө тогтоо

Хүмүүс яагаад хил хязгаарыг мэдэрдэг вэ? Яагаад гэвэл хүмүүс өөрт нь хийж чадах зүйл чадахгүй зүйл байдаг гэж боддог. Гэсэн ч Марк 9:23-т “Есүс түүнд: Хэрэв чаддаг бол гэв үү? Итгэлтэй хүнд бүх юм боломжтой” гэсэн байдаг учраас таны чадвар, хил хязгаар тань таны бодолтой шууд холбоотой. Тиймээс бид бодлоо итгэл болгон өөрчилж, Эзэн дотор юуг ч хийх боломжтой гэдгийг ухаарах хэрэгтэй.

Бид хил хязгаар, цар хүрээгээ тэлж том болгохыг бүх хүчээ дайчлан хичээх хэрэгтэй. Бурханы үг сургаалаар зэвсэглэж, гал халуун залбирахад Бурхан бидэнд энэрэл ивээлээ цутган өгч, Ариун Сүнсний тусламжтайгаар өөрийн хил хязгаараа ялан дийлж чадна. Бидэнд итгэл байвал боломжгүй зүйлийг ч боломжтой болгож чадна. Бүхнийг чадагч агуу Бурханы хүч чадлаар давуулан илүү сайнаар хийх хүчийг бидэнд өгдөг.

2

Бид өөрийн хязгаараа мэдрэх үед илрэн гарах явц ба түүнийг даван туулах арга

● Гутарч сэтгэлээр унах, сөрөг бодлуудаа хаяж итгэлээрээ баярлан талархах хэрэгтэй

Хэрэв бид махан биеийн бодлоороо сөрөг зүйл бодвол юу ч хийж чадахгүй зөвхөн гуныж гутарч, урам хугараад зогсохгүй хил хязгаараа ч ялан дийлж, дараагийн алхмыг ч хийж чадахгүй. Ийм байдалтай байвал бид эргээд хуучин байснаасаа ч бүр дор байдалд орно. Тиймээс гутрангүй, сөрөг бодлуудаа эерэг, баяр баясгалантай, өөдрөг бодлоор сольж, итгэлээрээ талархах хэрэгтэй. Ингэж бодлоо өөрчилж чадсаных нь хирээр Бурхан бидэнд хайр ивээл, энэрэл нигүүлсэлээ өгөх болно.

Яг ижилхэн зорилго тавьсан хоёр хүн байлаа гэж бодъё. Гэтэл нэг нь би үүнийг хийж чадна гэж байхад нөгөөх нь би чадахгүй нь ээ гэж хэлдэг. Ингэж итгэж найдсаныхаа дагуу эцэст нь хоёр өөр үр дүнд хүрнэ. Итгэлээрээ найдсан хүн эхний хүн шиг анхнаасаа л Бурханы хүслийн дагуу чин сэтгэлээсээ өөрийн хил хязгаар, хүрээгээ тэлж, ялан дийлэх эрч хүчтэй үйлчилдэг. Тиймээс бид ямар ч нөхцөл байдалд өөдрөг, эерэг бодол бодож Бурханд найдах хэрэгтэй байдаг.

Ингэж л сөрөг хандлага, бодлоос болж үүссэн урам хугарах, сэтгэл гутралаа ялан дийлэх болно. Тиймээс бид бүхэн өөрсдийн сэтгэлгээгээ, зүрх сэтгэлээ, оюун бодлоо үргэлж шалгаж, ямар ч нөхцөл байдалд баяртай байж, талархаж даван туулж, ялан дийлдэг байх хэрэгтэй.

● Бид чин сэтгэлээсээ Эзэнд талархах хэрэгтэй

Өнөө үед гэм нүгэл, ёс бус байдал маш их болж, Христийн бие болсон сүмийн загалмайг хүртэл шүүмжлэх болсон. Бурханыг хайрладаг пасторууд сүмийнхээ итгэгчдийг хамгаалах ёстой. Тиймээс тэд гэм нүгэл, ёс бус зүйлд хутгалдахгүй, сүмийнхээ итгэгчидээ гэмшүүлэхийн тулд анхаарал тавьж, дээрээс ирэх энэрэл хайр, ивээл нигүүлслийг авчрах чадвартай байх ёстой. Яг бидний Эзэн залбирал, загалмайн хайрын жишээгээр үзүүлсэн шиг золиос болон гал халуун, нулимс урсган залбирах залбирлыг шударга ёсны дагуу хураах шаардлагатай байдаг.

Бурхан бүх хүнийг аврал аваасай гэж үнэхээр их хүсдэг. Бурхантай хамт байдаг пастор хүний зуучлан залбирлаар дамжуулан Бурхан үзэсгэлэнтэй Тэнгэрийн Орон руу удирдаж, замчилж чадна. Тиймээс бид итгэлээрээ өөрчлөгдөж чадна гэж хэлж, ярьсанаар тусыг олохгүй. Хэрэв хэн нэг хүн одоог хүртэл хийж чадахгүй гэж бодсоор л байвал түүний зүрх сэтгэлд чин сэтгэлийн талархал байхгүй байна гэдгийг ухаарах хэрэгтэй.

Хэрвээ та Бурханы хайрыг, Эзэний хайрыг,

хоньчины хайрыг ойлгож ухаарах юм бол итгэлээрээ Бурханы хайранд найдаж, чин сэтгэлээсээ гүн талархсан залбирлыг өргөж, маш хурдан өөрчлөгдөн шинэчлэгдэх хүчийг авах болно.

● Гал халуун залбирлаар өөрийгөө ялан дийлэх хэрэгтэй

Хэрэв та залбирсан ч удаан өөрчлөгдөөд байвал танд гал халуун залбирал дутаад байна гэдгээ мэдэх хэрэгтэй. Зөвхөн гал халуун залбирлаар л та загалмай дээр өөрийнхөө бүх зүйлийг аваачих хүчийг авч чадна. Үүний яг эсрэгээр та бүх зүйлээ залбирал дотор байлгасан ч гэсэн өөрчлөлт маш удаан байх болно.

Зарим хүн залбирч гуйж эхлэхдээ чин сэтгэлээсээ залбирдаг ч залбирлынхаа төгсгөлд ямар ч утга учиргүй зүйлийг дахин дахин давтах эсвэл залбирлынхаа дундуур нойрмоглож зүүрмэглэдэг байна. Зарим хүн залбирал дуусахыг хүлээн шал дэмий зүйл бодож байхад зарим нь ядарч, залхдаг байна. Энэ нь чин сэтгэлээсээ өөрийн бүх зүйлээ загалмай дээр авчрахгүй байна гэсэн үг. Зарим нь махан биеийн бодлоороо л бодож, зуршил болгоод жинхэнэ зохих ёсоор залбирдаггүй байна.

Өөрийгөө ялан дийлэхийн тулд зөвхөн залбиралд л чухал ач холбогдол өгөх ёсгүй. Бид өөрчлөгдөхийн тулд тодорхой зорилго тавьж, өдөр бүр гал халуун залбирч хэвших хэрэгтэй. Бурханы хайр ивээл, хүч нь дээрээс ирж, энэ хүчээр бид ямар ч зүйлийг даван гарч, ялан дийлж чадна.

Бурханы Хүү Есүс хүртэл хөлсөө газарт цусан дусал болтол шаналан гал халуун залбирч байсан. (Лук 22:44). Тэгвэл бид яаж залбирах ёстой вэ? Лук 18-р бүлэгт нэгэн шударга бус шүүгчээс цөхрөлтгүй гуйж буй бэлэвсэн эмэгтэйн тухай сургаалт үлгэр байдаг. Бид энэ цөхрөлтгүй гуйж буй бэлэвсэн эмэгтэй шиг хариултаа авталаа цөхрөлтгүй цаг үргэлж гуйх ёстой юм.

Гал халуун залбирахгүй байх нь тэр хэмжээгээр зүрх сэтгэлээ өөрчлөхийг хүсэхгүй байна гэсэн үг. Бид өөрсдийгөө өөрчлөхийг хичнээн их хүссэн ч чаддаггүй харин гал халуун залбиралаар л бие, сэтгэл, дур хүсэл, бодол санаагаа өөрчилж чадна. Тиймээс өөрсдийн алдаа дутагдалаа, залбиралаа, өөрчлөгдөхийг хүсэн тэмүүлж байгаа хичээл зүтгэлээ ямар байгааг эргэн харж өөрийгөө мэдэхийг чин сэтгэлээсээ хүсвэл Бурхан бидэнд ойлгуулж, ухааруулж мэдүүлж өгдөг юм. Хэрэв бид гал халуун залбирч, итгэлээрээ үйлдвэл хэмжээлшгүй аз жаргал, баяр хөөрийг эдэлж, өдөр бүр өөрчлөгдөж шинэчлэгдсэн аз жаргалтай амьдралаар амьдрах болно.



Манмины 31 жилийн ойн баярыг тэмдэглэхээр Манмин Төв Сүмд 17 орноос хүмүүс хүрэлцэн ирсэн билээ. Ялангуяа Филиппин улсаас сүмийн ахлагч удирдагч, Манмин Сүмд хүрэлцэн ирж удирдагчийн семинарт оролцсон бөгөөд тэднээс *Манмин Мэдээ* сонины сурвалжлагчид ярилцлага авлаа.



Филиппинээс ирсэн астурууд хамтдаа Ариун Сүнс дүүрэх цуглааны дараа хамтдаа цугларан И Жей Руг тэргүүн пастортой уулзалт хийв (Зураг 1, 2). Зураг 3-зүүн гар талаас, Ериберто Кабаобао пастор, Селсо М.Сан Жөүс ахлагч, Елифанио Барселон пастор, Роберт А. Нери ахлагч, Марио Ж. Лоренте, Манюел Р. Бюеисүсесо пастор, Марио Роблес ахлагч.

А: Манмин төв сүм ирээд ямар сэтгэгдэлтэй байна?
Ахлагч нарын Холбооны дарга Селсо М. Сан Жөүс пастор, Хятад Улс

Би гурав дахь удаагаа Манмин төв сүмд ирж байна. Энэ сүмийн зохион байгуулалтын систем нь үнэхээр гайхамшигтай. Сүм бүр нь өөрийн гэсэн үйлчлэлтэй. Магтан дуу урлагын Зөвлөлийн үйлчлэл, GCN TV-ийн үйлчлэл, И Жей Руг тэргүүн пасторын үйлчлэлээр маш олон ном дэлхий даяар тархсан гээд үйлчлэлүүд нь маш гайхамшигтай санагдсан.

Мөн И Жей Руг тэргүүн пастор сүмийнхээ итгэгч нарт анхаарал халамж тавьж байгааг хараад маш их сэтгэл хөдлөсөн. Энд сүмийн олон автобус, машинууд итгэгчдийг сүмд ирж буцахад нь үнэ төлбөргүй үйлчилдэг, номын дэлгүүр, цайны газар, өндөр настай хүмүүсийг асарч халамжлах тоног төхөөрөмж гээд олон төрлийн үйлчлэлүүд байдаг. Энэ бүгдийг харахад тэр Христчин хүн хэрхэн даруу байх тод жишээ болж байгаа бөгөөд итгэгчид нь түүнд үнэнч итгэмжтэй байж, Бурханы хаанчлалын тулгуур багананууд болон өсөж байгааг харахад үнэхээр сайхан байна.

А: 2001 онд И Жей Руг тэргүүн пасторын Филиппинд хийсэн Нэгдсэн их цуглааны талаар бидэнд ярьж өгнө үү?
Кавайт Мужийн Христийн Холбооны дарга Роберт А. Нери пастор

Тус Цуглаан нь 2001 оны 9 сарын 26 наас эхлээд дөрвөн өдөр үргэлжилсэн. Филиппинд 9-р сар хар салхины үе байдаг тул олон пасторууд санаа зовж байлаа. Яг цуглаан эхлэхийн өмнө И Жей Руг тэргүүн пастор ярилцлага өгөхдөө цуглаан амжилттай явагдах болно гэж хэлсэн түүний үгийг Бурхан агуу их хүч чадлаараа баглан харуулсан билээ. Тэр үед хоёр

хар салхи ирж явсан боловч нэг нь чиглэлтэй өрчлөн нөгөө нь замхран алга болсон билээ. Дөрвөн өдрийн турш бороо ороогүй харин сарыг тойрсон дугуй солонго татсан байхыг бид харсан.

Номлолын дараа түүний өвчин эдгээх залбирлаар үй олон хүн өвчинөөсөө эдгэрч Бурханыг алдаршуулсан билээ. Яг энэ үед олон пасторууд эрх мэдэлт хүч, тэмдэгт гайхамшигуудыг хараад сэтгэл нь догдолж байлаа. Бурхан И Жей Руг тэргүүн пастортой хамт байгаа хараад итгэл нь илүү их өсөж, сүм чуулганууд сэргэж, ариун зар мэдээг Филиппинд үргэлжлүүлэн эрч хүчтэйгээр тараасаар байгаа билээ.

А: Марио ерөнхий удирдагчаа, таныг энэ удаагийнхаа айлчлалаар гайхалтай ивээл ерөөлүүдийг авсан гэж би сонсон.

Марио Роблес Пастор PMI-ийн Ерөнхий удирдагч (Филиппины Миссионерийн Институт)

Миний хувьд Манмин төв сүмд хүрэлцэн ирсэн нь асар их ерөөл юм. Энэ бүгдээс хамгийн гайхамшигтай ивээл нь Бурхантай хамт байдаг И Жей Руг тэргүүн пастортой уулзаж, түүний ерөөлийн залбирлыг авсан явдал юм. Түүний даруу зан, сайхан сэтгэлийг би үнэхээр их мэдэрсэн юм. Сүмийн итгэгчид мөргөлийн үеэр чин сэтгэлээсээ сүнсэн дотор магтан дуулж, сайн үйлс, сайхан сэтгэлээрээ бидэнд халуун дотноор үйлчилж, халамж анхаарал тавьж байлаа. Энэ нь тэргүүн пасторын Бурханы Үгийн дагуу амьдарч ирсэн үлгэр жишээгээр мөн чин зүрхнээсээ номлосоноор ийм үр дүнд хүрсэн байх гэж би бодож байна.

Филиппины Миссионерийн Институтын ерөнхий удирдагчын хувьд би энэхүү ариун сайн мэдээ, сургаалыг сургуулийнхаа багш, оюутануудаа заахыг маш их хүсэж байна. Мөн Филиппины Миссионерийн Холбооны даргын

хувьд энэ ариун сургаалыг залуустаа хэлж, мэдүүлмээр байна.

А: Та Муан Амгат Усаар эдгэрсэн гэсэн үү?
Марио Ж. Лоренте пастор, GMA дэх Сүм

Жеоннам аймгийн Муан-гүны далайн шорвог усыг Сөүлээс И Жей Руг тэргүүн пасторын залбирлаар амгат ус болгон хувиргасан нь үнэхээрийн гайхамшигтай Бурханы эрх мэдэлт хүч байсан. Би И Жей Руг Тэргүүн пасторыг жинхэнэ цэвэр зүрх сэтгэлтэй Бурханы хүн учраас бүх юм боломжтойгоор хийгддэг гэдэгт итгэдэг. Би бас Муан Амгат усны Аквариумд далайн усны загас цэвэр усны загас хоёр хамтдаа амьдарч байхыг хараад ёстой мэл гайхсан. Бурханы хувьд боломжгүй зүйл гэж юу ч байхгүй.

2011 онд би сарын турш хоолойн өвчнөөр маш их шаналж байсан. Манмин Төв Сүмд ирээд Муан Амгат усыг ууж эв эрүүл болсон. Энэ удаагийн 2013 оны айлчлалаараа нуруу, мөр өвчтэй байсан болохоор Муан Амгат Усны газар очиж шумбаад хоёулаа зүв зүгээр болж эдгэрсэн. Халлелуяа!

А: Та И Жей Руг тэргүүн пасторын номнуудыг уншиж үзсэн үү?
Мануэл Р. Бюенсүсесо Пасторуудын Холбооны өмнөх дарга, Манила Пасей хот

Би “Итгэлийн Хэмжээ”, “Сүү, зөгийн балаар бялхсан газар нутаг”, “дуулгавартай ба дуулгаваргүй амьдрал” гэсэн номнуудыг уншсан. “Итгэлийн Хэмжээ” гэдэг ном нь надад маш их таалагдсан. Энэ ном бидний итгэлийн өсөлт болон Бурхан биднийг Өөр шигээ ариун байх талаар онцлон дурдсан байдаг.

Түүний номнууд надад Эзэний өдрийг ариунаар сахиу, өөрийгөө үгүйсгэх, дуулгавартай байдал гэх мэт Бурханы хүслийг маш тодорхойгоор ойлгуулж өгсөн. Би эрдэнэсээр дүүрэн үнэ цэнэтэй сургаалтай түүний номнуудыг пасторуудад, миний эргэн тойронд байгаа хүмүүст болон итгэгчидэд тараасаар байгаа.

А: Та Даниел Залбиралд оролцсон сэтгэгдлээсээ хуваалцана уу?
Елифанио Барселон пастор, Дасмаринас хотын Христийн Холбооны дарга

Яг үнэндээ би орой болгон 9 цагт хийдэг Даниел залбиралыг маш их гайхаж байсан Итгэгчид цагаасаа өмнө ирээд өөрсдийгөө бэлдэж, залбирлын үер бүгд хамтдаа чанга дуугаар хашхирч байсан. Энэ бүгдийг хараад миний сэтгэл маш их хөдлөсөн. Сүмд залбирч байхад Ариун Сүнсний тосолгоог би харж мэдэрсэн. Миний дотор үгээр илэрхийлэхийн аргагүй амар тайван болж, маш их өөрчлөгдсөн. Манай сүм залбиралынхаа цагийг нэмж, Бурханд илүү их залбиралаар өргөл өргөхөөр төлөвлөж байгаа.

А: 31 жилийн ойн баярын Урлагын тоглолтын талаар та юу гэж бодож байна?
Ериберто Кабаобао PMF (Филиппины Миссионерийн Холбоо)-ийн өмнөх дарга

Олон сайхан үзүүлбэрүүдийг маш эв нэгдэлтэй, эмх цэгцтэй, залуу хүмүүс гэхэд Эзэнийг гал халуун хайрласан гайхамшигтай байсан. Үлгэрийн юм шиг тайз, хувцас хэрэгсэл нь бусад олон нэвтрүүлэг, урлагын тоглолтоос хамаагүй сайн, мэргэжлийн өндөр түвшинд байгаа нь харагдсан. Нэг их зардал мөнгө, цаг хугацаа зарцуулахгүйгээр ийм гайхалтай сайхан урлагын тоглолтыг би урьд үзэж байсангүй. Миний үзэж байсан тоглолтуудаас дээд зэргийн бүр дэлхийн хэмжээнд яригдахаар тоглолт байсан. Христчин хүмүүсийн хувьд Тэнгэрийн орны итгэл найдварыг төрүүлж чадсан. Тэнгэрийн орны үзэсгэлэнтэй, цэвэр ариун, сүр жавхлантай байдлыг нь илэрхийлж байгааг хараад Тэнгэрийн оронд яг ийм ариун хүмүүс л орж чадах байх даа гэж бодогдсон. Тийм учраас ариун амьдралаар амьдрахын тулд би бүр илүү их хичээн зүтгэх хэрэгтэй гэж бодсон.

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:
Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин